



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 108

Номгон

Г “Сурын харвааны цогцолбор” барих
зураг төсвийн санал боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 10 дугаар сарын 01-ний “Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай” 133 дугаар зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Заг сумын түүхт нутаг “Хүрэн бэлчир”-т аялал жуулчлалыг хөгжүүлэх, тухайн орон нутгийн иргэдийн аж амьдрал, соёлыг түгээн дэлгэрүүлэх, ард иргэдийг ашиг орлоготой болгох зорилгоор “Сурын харвааны цогцолбор” барих зураг төсвийн санал боловсруулах, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: М.Батбаяр-Аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны дарга

Гишүүд: Т.Галсан-Монгол Улсын Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн

С.Дулам-Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор, доктор, ардын багш

П.Дэлгэржаргал-Монгол Улсын Их сургуулийн доктор

Ц.Төмөрбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, Эрдэнэцогт сумын Засаг дарга

Т.Нямжаргал-Заг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Д.Мөнхнасан-Заг сумын Засаг дарга

Д.Сайнбилэг-Жаргалант сумын Засаг дарга

М.Мэнджаргал-Аймгийн Биеийн тамир спортын газрын дарга

А.Мандах-Аймгийн Түүх угсаатны зүй-Байгалийн музейн дарга

М.Мөнгөнцэцэг-Аймгийн Улаан загалмайн хорооны дарга, сумын мэргэн

С.Баярмагнай-Монголын барилгын үндэсний ассоциацийн зөвлөх

1190187

Д.Содномсамдан-Аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны ахлах мэргэжилтэн

Б.Мөнх-Эрдэнэ-Спортын мастер, аймгийн мэргэн

Ю.Мөнхжин-Аймгийн Цагдаагийн газрын эмч, спортын мастер, аймгийн мэргэн

Б.Мөнхбат-Аймгийн гарамгай харваач

Д.Солонго-Аймгийн мэргэн

Ц.Орхон-"ЦЭСДА" ХХК-ний захирал

П.Дэлгэрсайхан-Уран барималч

2. Сурын харвааны цогцолборын зураг төсөв боловсруулж, төслийг 2020 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР